



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар A/49

Улаанбаатар хот

Г Заавар, аргачлал шинэчлэн
батлах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох "Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж дүгнэлт гаргах заавар"-ыг нэгдүгээр, "Хандивын тайлангийн дүгнэлтийн загвар"-ыг хоёрдугаар, "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн "Заавар батлах тухай" A/47 дугаар тушаал, 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн "Аргачлал батлах тухай" A/56 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тушаалаар баталсан заавар, аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор нарт, аудитыг байнгын нэгтгэсэн хяналт, удирдлагаар хангаж ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, тэргүүлэх аудитор (Я.Самбууняа)-д үүрэг болгосугай.

5. Заавар, аргачлалыг аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын албан хаагчдад хүргэх, олон нийтэд цахимаар түгээх ажлыг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол)-д үүрэг болгосугай.


Д.ЗАГДЖАВ

**НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧЭЭС ИРҮҮЛСЭН ХАНДИВЫН
ТАЙЛАНГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар Аймаг, нийслэл, сум; дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7, 37.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргахдаа энэхүү зааврыг ашиглана.

1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.

1.3. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь нам, эвслээс холбогдох хууль тогтоомж болон энэхүү зааврын хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж ирүүлсэн хандивын тайланг холбогдох төрийн байгууллага, арилжааны банкнуудаас гаргуулан авсан лавлагаа, мэдээлэл, судалгаатай тулган хянан баталгаажуулж дүгнэлт гаргах бөгөөд нам, эвслийн хандивын тайланд тусгагдаагүй аливаа хандивыг хянан баталгаажуулахгүй болно.

Хоёр. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргахад шаардлагатай нотлох баримт цуглуулах, үнэлэх аргачлал

2.1. Аудит гүйцэтгэх баг нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргахад дараах ажиллагааг гүйцэтгэн, шаардлагатай тайлан, судалгааг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна. Үүнд:

- 2.1.1. Хууль, эрх зүйн орчныг судлах;
- 2.1.2. Өмнө зохион байгуулагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит болон ээлжит бус, нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланд хийсэн Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, тайланг судлах;
- 2.1.3. Намуудаас сонгуулийн жилийн өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, энэхүү зааварт заасан маягтын дагуу бэлтгэсэн хандивын тайлан, холбогдох баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хугацааны дотор гаргуулан авах;
- 2.1.4. Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайлан нь МАЯГТ 1, 2-т заасны дагуу мэдээллийг бүрэн мэдээлээгүй, санхүүгийн болон хандивын тайлангийн мэдээлэл илэрхий зөрүүтэй бол шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, тодруулга авч болно.

2.2. Аудитын баг нь энэхүү зааврын 2.1-т заасан тайлан, мэдээ, судалгаанд үндэслэн дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 2.2.1. Хандивын тайлангаа хянуулж, баталгаажуулахаар ирүүлсэн нам, эвслийн тайлагнасан хандивын дансны хуулга, тухайн намд холбогдох бусад мэдээллийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.11-д заасны дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасан хугацаагаар арилжааны банкнуудаас гаргуулан авах;
- 2.2.2. Нам, эвслийн ирүүлсэн хандивын тайланд хамаарах хуулийн этгээдийн талаарх холбогдох мэдээлэл, лавлагааг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.6, 55.1.7-д заасны дагуу улсын бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагаас, мөн хуулийн 55.1.1-д заасны дагуу лавлагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тус тус гаргуулан авах.

2.3. Аудитын багийн аудиторууд намаас ирүүлсэн хандивын тайланг арилжааны банкнаас ирүүлсэн дансны хуулга, төрийн байгууллагын лавлагаа. мэдээлэл. Судалгаатай тулган хянаж. нотлох зүйлсийг үнэлж. баримтжуулна.

Гурав. Нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах аргачлал

3.1. Нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргахад дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 3.1.1. Цуглувансан нотлох зүйлсийг үнэлж, санхүүгийн тайлан болон хандивын тайлан, бусад холбогдох лавлагаа, мэдээлэлд боловсруулалт хийж энэхүү зааврын хавсралтаар батлагдсан МАЯГТ 3, 4-ийн дагуу нэгтгэл гаргана.
- 3.1.2. Дүгнэлт болон нэгтгэл гаргах боломжгүй тохиолдолд ирүүлсэн хандивын тайланг тухайн намд буцааж албан бичгээр хүргүүлнэ.
- 3.1.3. Аудитын баг нь нэгтгэл болон нотлох баримтад дүн шинжилгээ хийж. Загварын дагуу дүгнэлтийн төсөл боловсруулан үе шатны хяналт хийлгэнэ.

Дөрөв. Хандивын тайлангийн дүгнэлт

4.1. Аудитын баг хандивын тайлан ирүүлсэн нам, эвсэлд хүргүүлэх дүгнэлтийн төслийг боловсруулж, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторт танилцуулан, албажуулна.

4.2. Улс төрийн намаас ирүүлсэн хандивын тайлангийн хувийг 'ДҮГНЭЛТ"-ийн хамт Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд нам, эвсэлд хүргүүлнэ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
A/49 дугаартай тушаалын хоёрдугаар
хавсралт

ХАНДИВЫН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит, ээлжит бус, нөхөн/ сонгуульд оролцох намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай Хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын оны ээлжит/ээлжит бус, нөхөн/ сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит (ээлжит бус, нөхөн) сонгуульд оролцох ... намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.



Дүгнэлт

Хувилбар-1

.....намын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны (ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн) хандивын тайланда тусгасан нийт(бичгээр) төгрөгийн хандивыг Улс төрийн намын тухай хуулиар тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан байна.

Хувилбар-2

..... намын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны (ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн) хандивын тайланда тусгасан нийт (бичгээр) төгрөгийн хандиваас Улс төрийн намын тухай хуулийн /хуулийн заалтыг бичнэ/ заалтад нийцээгүй (бичгээр) төгрөгийн хандив хүлээн авсан байна.

Нам, эвслээс ирүүлсэн хандивын
тайланг хянан баталгаажуулж
дүгнэлт гарах заварын хөбөрлэлт

МАЯГТ-1

Аймаг, нийслэл, сум, дуургийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох
нам, эвсэл, бие даван нэр дэвшигчид "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлантийн маягт

.....нам, эвслийн нэр

/мийн төгрөг/

Д/д	Иргэний нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл						Хандив хулзэн авсан хандивын ментэн дун	Огноо	Банкны нэр	Дансны дугаар	Г/мийм, Үгүй/	Тийм бол ментэн дун	Хандивыг буцаасан дансны дугаар	Хандивыг буцаалага хандивыг шалтгаалж	Тайлбар	
		Иргэний бүртглийн дугаар	Нас	Иргэншил	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл	Оршин суугаа хаяг	Утасны дугаар										
1	2	3	4	5	6	7	8	2023 оны 01 дугаар сарын 01-нэээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд	9	10	11	13	14	15	16	17	
1	2	3	4	5	6	7	8	2024 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд	9	10	11	13	14	15	16	17	
2																	
3																	

Санамж: Аймаг, нийслэл, сум, дуургийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд
мен хуулийн 53, 54, 55 дугаар зүйд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана. Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд

Тамга, тэмдэг

Хянасан:

Албан тушаал
Овог нэр
Гарын үсэг

Боловсруулсан:

Албан тушаал
Овог нэр
Гарын үсэг

Нам. эвслийсэн хандивын
тайланг хянан багалгаажуулж
дүгнэлт гаргах заасны хавраамт

МАЯТ-2

Бонж

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох
нам, эвсал, бие даан нэр дэшигчид "Хуулийн ЭТТ ЭЭД"-ээс өгсөн хандивын дэлгэрэнгүй жагсаалт

.....нам. эвслийн нэр

Хуулийн нэр этээдийн мэдээлэл		Хандивын хуулийн этээдийн мэдээлэл				Хандивын хулээн авсан				АИСДИТХ-н сонгуулийн тухай хуулийн 53.4.-т заасан хандивын мэдээллийн шаардлага хангагч хандивыг буцаан шилжүүлсэн эсэх						
Д/а	Хуулийн нэр этээдийн Регистерийн дугаар	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулсан отноо	Үйл ажиллагааны чиглэл	Хариуцлагын хэлбэр	Оноо	Банкны нар	Дансны дугаар	Хандивын мөнгөн дүн	Гийм, Үгүй/ Мянган дүнч	Тийм бол мянган дүнч	Хандивыг булаасан дурсгалыг дугаар бичих	Булах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлоготоо бууруулж, санд шилжүүлсэн тохиолдолт огноо, дансны дугаар бичих	Тайлбар	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1																
2																
3																
1																
2																
3																

Санамж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд мөн хуулийн 53, 54, 55 дугаар зүйлд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана. Харин намын дүрэм, дотоод, зохион байгуулалтын үүл ажиллагаанд зориулан

Тамга, Тэмдэг

Хянасан:

Албан тушаал

Овог нар

Гарын үсэг

Боловсруулсан:

Албан тушаал

Овог нар

Гарын үсэг

МАЯГЧИЛАН

АНДСИТХЫН эзлэхт /эзлжигт бус, нөхөн/ сонгуульд оролцохнаам, эвсэл болон бие даан нар давшиг чид "Хүүлийн этгээд"-ээс өгсөн хандивын тайллангийн насттэй

.....HAM, EBCUNDH HED

Ханак:	Арбак Түшән	Оңтүсп	Гарын Чөгө
Есесоруссан:	Арбак Түшән	Оңтүсп	Гарын Чөгө



Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
049 дугаар тушаалтын гуравдугаар хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ БОЛОН БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ
АРГАЧЛАЛ**

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн /АНСДИТХСтХ/-ийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.3, 5.4 дэх хэсэгт заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргахад энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Төрийн аудитын байгууллага энэхүү аудитыг хийхдээ Төрийн аудитын тухай хууль, MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандарт болон бусад хууль, журмыг баримтлан ажиллана.

1.3. АНСДИТХСтХ-ийн 37 дугаар зүйлийн 37.6-д заасан хугацаанд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад ирүүлэх ба аудитын баг АНСДИТХСтХ-ийн 37 дугаар зүйлийн 37.10, 37.11-т заасан хугацаанд дүгнэлт гаргана.

Хоёр. АУДИТЫН ҮЕ ШАТНЫ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

2.1. Төрийн аудитын байгууллагаас нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийх нийцлийн аудит нь дараах үе шаттай байна. Үүнд:

- 2.1.1. аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат;
- 2.1.2. аудитыг төлөвлөх үе шат;
- 2.1.3. аудитыг гүйцэтгэх үе шат;
- 2.1.4. аудитын дүгнэлт гаргах үе шат.

Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат

2.2. Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шатанд аудитын багийг томилох, урьдчилсан судалгаа хийж ойлголттой болох, аудитын ажлын нөхцөлийг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид танилцуулах ажлыг хэрэгжүүлнэ.

2.3. Томилогдсон аудитын багийн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдэгдэл тайлбар болон нууцын баталгааг гаргуулж баталгаажуулна.

2.4. Аудитын баг дараах эрх зүйн баримт бичгийг судалсан байна. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хууль;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал;
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагатай холбоотой бусад эрх зүйн баримт бичгүүд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг;
- Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын хэрэгжилтийн тайлан;
- Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;
- Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нам, эсвэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт ҮАГ-аас гаргасан дүгнэлт, баталгаажсан мөрийн хөтөлбөр;
- Орон нутгийн тухайн оны төсвийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, дараах оны төсвийн төсөл, холбогдох оны төсвийн төсөөлөл;
- Өмнөх аудитын архивын баримт материалууд.

2.5. Нам, эсвэл, бие даан нэр дэвшигчид аудитын ажлын нөхцөлийг танилцуулах аудитын ажлын захидалтыг илгээнэ. Ажлын захидалтын загварыг энэхүү аргачлалын 1 дүгээр хавсралтын загвар маягтын дагуу бэлтгэн улс төрийн нам, эсвэлд хүргүүлнэ. Аудитын баг шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл гаргуулах хавсралт боловсруулж, ажлын захидалд нэмж хавсаргаж болно.

2.6. Бие даан нэр дэвшигчид аудитын ажлын захидалтыг сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлэх үед гардуулахаар бэлтгэсэн байна.

Аудитын төлөвлөлтийн үе шат

- 2.7. Аудитын баг аудитыг төлөвлөхдөө дараах үе шатны ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.7.1. аудитын эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, эрсдэлийг үнэлж баримтжуулах;
 - 2.7.2. аудитын материаллаг байдлын түвшин тодорхойлох;
 - 2.7.3. аудитын горим, сорилыг боловсруулж хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох;
 - 2.7.4. аудитын төлөвлөгөөг боловсруулж батлуулах.

Эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, эрсдэлийг үнэлж баримтжуулах

2.8. Аудитын эрсдэлтэй асуудлыг тодорхойлохын тулд нам, эсвэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулахдаа холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж ирүүлээгүй байж болох эрсдэлийг авч үзнэ.

2.9. Аудитын баг аудитын турш шаардлагатай тохиолдол бүрд эрсдэлийг үнэлж, аудитын горимуудыг гүйцэтгэнэ. Аудитын эрсдэлд дараах асуудлууд хамаарч болох юм.

2.9.1. нам, эвсэл, бие даан нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нийцүүлэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээгээ боловсруулсан эсэх;

2.9.2. нам, эвсэл, бие даан нэр дэвшигч "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлогын бусад баримт бичигт нийцүүлэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг боловсруулсан эсэх;

2.9.3. нам, эвсэл, бие даан нэр дэвшигч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагатай холбоотой бусад эрх зүйн баримт бичгүүдтэй нийцүүлэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг боловсруулсан эсэх;

2.9.4. мөрийн хөтөлбөрт холбогдох хуулиудад нийцээгүй зорилт, арга хэмжээг далд агуулгаар тусгасан эсэх;

2.9.5. аудитын багийн аудитын явцад гарч болох бусад эрсдэлтэй асуудлууд байгаа эсэх.

2.10. Аудитыг төлөвлөх үед холбогдох журмын дагуу эрсдэлийг тооцож төлөвлөгөөний хавсралтаар баримтжуулсан байна.

Материаллаг байдлын түвшин тодорхойлох

2.11. Аудитын баг материаллаг байдлыг тоон болон чанарын хүчин зүйлээр авч үзнэ. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь үзүүлэх үр дагавар их, олон нийтийн анхаарал татах магадлал их учраас материаллаг байдлын түвшин хамгийн бага байхаар төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд үнэлнэ.

2.12. Аудитын гүйцэтгэлийн үе шатанд нотлох зүйлийг үнэлэх үед мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний аль нэг заалт, агуулга, нэр томьёо холбогдох хууль, урт хугацааны бодлого, хөгжлийн бодлогын бусад баримт бичигийн нэг болон түүнээс дээш заалттай нийцэхгүй, мөн санхүүгийн эх үүсвэр шаардлагатай арга хэмжээнд тооцоолол хийгээгүй эсхүл тодорхойгүй, тэдгээрийн нийлбэр нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцээгүй байвал материаллаг гэж үзнэ.

Аудитын төлөвлөгөөг боловсруулж батлуулах

2.13. Аудитын баг аудитыг АНДИТХСтХ-д заасан богино хугацаанд чанартай гүйцэтгэхээр төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулна.

2.14. Аудитын төлөвлөгөө нь аудитад хяналт тавих гол баримт бичиг бөгөөд аудитын зорилго, зорилт, хамрах хүрээ, аудитын эрсдэл, аудитад ашиглах арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа, аудитыг гүйцэтгэх багийн гишүүд/ажлын хэсэг, аудитын төсөв зэргийг тусгасан төлөвлөгөөг аудитын баг боловсруулж, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитороор батлуулна.

Аудитын горим, сорилыг боловсруулж хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох

2.15. Аудитын баг илрүүлэлтийн эрсдэлийг хамгийн бага байлгахаар мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ тус бүрийг шалгах дэлгэрэнгүй горим, сорилыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.16. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ бүрд дэлгэрэнгүй горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн үе шатанд ажлын баримтын маягт зааврыг боловсруулна.

2.17. Ажлын баримтын маягт (шалгах хуудас)-ыг энэхүү аргачлалын 2, 3, 4 дүгээр хавсралт маягтын дагуу боловсруулна.

Аудитыг гүйцэтгэх үе шат

2.18. Аудитыг гүйцэтгэхийн өмнө сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хүлээн авах бэлтгэлийг хангасан байна. Хүлээн авах аудитын багийн гишүүдийг томилсон байх бөгөөд мөрийн хөтөлбөрийг тусгайлсан битүүмжлэлтэй газар хадгална.

2.19. Нам, эвслийн болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг албаны нууцын зэрэглэлийн түвшинд адилтган авч үзэж, аудитын багийн гишүүд нууцыг чандлан хадгална.

2.20. Тухайн нэгжийн аудитын менежер, ажлын хэсгийн ахлагч, нарийн бичиг эсхүл тусгайлан томилогдсон албан хаагч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавина.

2.21. Аудитыг гүйцэтгэхдээ дүгнэлт гарахад дэмжлэг үзүүлэх нотлох зүйлсийг цуглуулах, бүрдүүлэх, тэдгээрийг үнэлэх, дүн шинжилгээ хийж батлагдсан төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэнэ.

2.22. Аудитыг гүйцэтгэх үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

- 2.22.1. аудитын горимуудыг хэрэгжүүлэх;
- 2.22.2. аудитын нотлох зүйлсийг цуглуулах;
- 2.22.3. аудитын нотлох зүйлсийг үнэлэх;
- 2.22.4. дүгнэлт гаргах;
- 2.22.5. баримтжуулалт хийх.

2.23. Аудитор нам, эвсэл, бие даан нэр дэвшигч тус бүрд энэхүү аргачлалын 2, 3, 4 дүгээр хавсралтаар батлагдсан маяттууд, шалгах хуудсыг ашиглан дүгнэлт гаргах ажлын баримтыг бүрдүүлсэн байна.

2.24. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ тус бүрийг АНСДИТХСтХ-ийн 37.3-т заасан хориглосон арга хэмжээ байгаа эсэхийг энэхүү аргачлалын 2 дугаар хавсралтын дагуу хянана.

2.25. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний материаллаг бөгөөд эрсдэлтэй асуудлыг сонгон энэхүү аргачлалын 3, 4 дүгээр хавсралтын дагуу хянана.

2.26. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ ойлгомжгүй томьёологдсон, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй бол холбогдох

албан тушаалтан болон хүмүүстэй ярилцлага хийх, тодруулга авах, нэмэлт баримт материал гаргуулах, асуулга авах, ажиглалт хийх зэрэг бусад нотлох зүйл цуглуулах арга зүйг хэрэгжүүлнэ.

2.27. Аудитын өдөр тутмын чанарын хяналтыг аудитын менежер, тэргүүлэх аудитор нар Чанарын хяналтын журмын дагуу хэрэгжүүлнэ.

Аудитын дүгнэлт гаргах

2.28. Аудитын илрүүлэлт ба материаллаг байдалд үндэслэн аудитор нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр бүх талаараа материаллаг байдлын хувьд холбогдох шалгууртай нийцэж байгаа эсэхийг үнэлж, дүгнэнэ.

2.29. Аудитын дүгнэлт гаргах үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

2.29.1. аудитын үр дүнг нэгтгэнэ;

2.29.2. материаллаг байдлыг дахин авч үзнэ;

2.29.3. аудитын шалгууртай харьцуулан дүгнэлт гаргана.

2.30. Хэрэв материаллаг зөрчил илэрвэл АНСДИТХСтХ-ийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу шаардлага хангаагүй гэсэн дүгнэлтийг гаргаж, нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид тав хоногийн дотор уг зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин ирүүлэхээр хүргүүлнэ. Энэхүү дүгнэлтийг аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор баталгаажуулна.

2.31. Хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлтийг энэхүү аргачлалын 5 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргана.

2.32. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр материаллаг байдлын хувьд холбогдох хуульд заасан шаардлагатай нийцэж байвал нийцсэн дүгнэлтийг гаргана. Дүгнэлтийг аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор баталгаажуулна. Ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь хуульд нийцсэн талаарх дүгнэлтийг энэхүү аргачлалын 6 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргана.

2.33. Аудитын баг тухайн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн, үл нийцсэн талаар дүгнэлт гаргасан үндэслэлийг холбогдох нам, эвслийн эрх бүхий албан тушаалтан, бие даан нэр дэвшигчид танилцуулна.

2.34. Гаргасан дүгнэлтийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10, 37.11-д заасны дагуу тухайн шатны Сонгуулийн хороонд хүргүүлнэ.

2.35. Аудитын баг нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн дүгнэлт гаргасан сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд өгсөн аудитын эцсийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанд цахим хуудаст нээлттэйгээр байршуулна.

2.36. Аудитын баг холбогдох бүх ажлын баримт материал, нотлох зүйлсийг иж бүрэн, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу нэгтгэж, архивын нэгж болгон бэлтгэж архивд авна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын
... оны ... дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын нэгдүгээр хавсралт

Маягт А

Ажлын захидалтын загвар, маягт

..... /АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ/-ИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЛИЙН УДИРДЛАГА ТАНАА

**Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.3, 5.4 дэх хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллага Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргахаар заасан. Энэхүү зохицуулалтын хүрээнд сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт аудит хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

1. Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд MNS 6817 : 2020 – Төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэх ба дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1 Улс төрийн нам/эвсэл/бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалт байгаа эсэхийг хянах;

1.2 Мөн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцсэн эсэхийг хянах;

1.3 Улс төрийн нам/эвсэл/бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь хуульд заасан Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах;

1.4 Тодруулах зүйлсийг тухай бүр мэдэгдэх бөгөөд аудитын явцад удирдлагаас нэмэлт мэдээлэл, тайлбар авах;

1.5 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй дүгнэлт гарсан

тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгуулж, дахин дүгнэлт гаргах зэрэг болно.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нам, эвсэл нь дараах үүрэг хариуцлагыг хүлээж байна. Үүнд:

2.1 Нам/ эвсэл/ бие даан нэр дэвшигч нь мэрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагат хүргүүлсэн байх; /Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 37.6/;

2.2 Нам/ эвсэл/ бие даан нэр дэвшигч нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө илэрхийлэхдээ дээрх дүгнэлтийг гаргуулсан байх /Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.4, 25.4.4/;

2.3 Нам/ эвсэл/ бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мэрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулах;

2.4 Нам/ эвсэл/ бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мэрийн хөтөлбөр болон түүнд дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл /энэхүү захидалын нэг ба хоёрдугаар хавсралт/ мөн мэрийн хөтөлбөрийн З эх хувийг¹ хэвлэмэл байдлаар, хувийг /файл хэлбэрээр/ дугтуйнд хийж битүүмжлэлтэйгээр тоот/-д ажлын цагаар хүлээлгэн өгнө. Дугтуйн дээр нам, эвслийн нэрийг гаргацтайгаар бичсэн байна. /Хэрэв эвсэл бол хуульд заасан журмын дагуу эвсэл байгуулагдсан талаарх нотлох баримтын хамт/

Иймд аудит гүйцэтгэх хугацаанд сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих мэрийн хөтөлбөрийг шаардлагатай баримт, материалын хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлэх, аудитын зорилгоор хүссэн нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр баталгаажуулж өгөх, аудитын нотолгоог олж авах нөхцөл, боломжоор хангаж ажиллана уу.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн нам, эвслийг төлөөлөн шууд харилцах эрх бүхий албан тушаалтныг томилж, холбогдох нотлох баримтын хамт ирүүлж, уг албан тушаалтан өөрчлөгдөх бүрд Төрийн аудитын газарт бичгээр мэдэгдэнэ үү.

Аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд харилцан хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Жич: Талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага болон бидний гүйцэтгэх аудитын нөхцөлтэй танилцсан гэдгээ илэрхийлж хариуг албан ёсоор ирүүлнэ үү.

Хавсралт . . . хуудастай.

¹ Мэрийн хөтөлбөрт дүгнэлт гаргасан дүгнэлтийг эх хувиар 3 газар хэрэглэнэ. 1% -ийг ТАБ-д, 1% -ийг СЕХ-нд, 1% -ийг нам эвсэл, бие даан нэр дэвшигчид баталгаажуулан хүргүүлнэ.

Хүндэтгэсэн,

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /гарын үсгийн
тайлал/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР /гарын үсгийн тайлал/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

АУДИТОР /гарын үсгийн тайлал/

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024. оны 04 дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын нэдүгээр хавсралт (Маят Б)
..... аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын 2024 оны ... дугаар сарын ...-ний
өдрийн ... дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

**Аймаг, нийслэл, сум, дуургийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зуйлийн 37.5.
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.3, 5.4-т заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан улс
төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн хавсралтаар ирүүлэх мэдээлэл**

№	Нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Шаардлагах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг баримталсан эсэх (тийм, угүй)	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр, холбогдох заалтыг бичих	A	1	2	3
1							
2							
...							

Жич: - 2 дугаар бааганад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцоолоходоо төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний
мэдэгдлийг баримталсан эсэх
хөгжлийн бодлогын ямар баримт бичгийн аль заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.

Мэдээллийг бэлтгэсэн _____
Нам/эвслийн/нэр

(тэмдэг) _____
албан тушаал
(тэмдэг) _____
албан тушаал

овог нэр
овог нэр
2024 оны ... сарын ... өдөр

-ыг төлөөлж
гарын үсэг
-ыг төлөөлж
гарын үсэг

~~Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 9/49 дугаар тушаалдаар батлагдсан
аргачлалын нэгдүгээр хавсралт (Маягт В)~~

~~Дидитын газрын 2024 оны ... дугаар сарын ...-ний
... дугаар албан бичийн хоёрдугаар хавсралт~~

..... аймаг, нийслэл дэх төрийн газрын 2024 оны ..дугаар сарын: -ний
өдрийн ... дугаар албан бичгийн хөрдүгаар хавсралт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн хавсралтаар ирүүлэх мэдээлэл

/сая төрөгөөр/

№	Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Хамрах хугацаа	Шаардагдах санхүүгийн эх үүсвэр (Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 20.2.1-20.2.6 дахь заалт)	Шаардагда х санхүүгийн эх үүсвэрийн нийт дүн	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ төсвийн жил тус бурээр		Тайлбар
					Уусвэр	Тус бурээр	
1	Жишээ: “Төсөвийн дэмжлэгтэй бүтээн босголт, хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээний нэр”	Жишээ:	Жишээ:	Жишээ:	Жишээ:	Жишээ:	Жишээ:
2	Бугд дүн	20.2.1.улсын төсөв;	1'626.2	406.6	406.6	Санхүүжилтийг 4 жилд тэнцүү зарцуулахаар төлөвлөв.

Жич:

- 3 дугаар баганад шаардлагдах санхүүгийн эх үүсвэр нь ХБТТУТХ -ийн 202.6 дахь заалтад хамаарна гэж мэдээлсэн тохиолдолд энэ ангилалд хамааруулах үндэслэл, тайлбар, нотлох зүйлийн хамт ирүүлнэ.

Мэдээллийг бэлтгэсэн _____ -ыг төлөөлж

(тэмдэг)	албан тушаал	овог нэр	Нам/Эвслийн/нэр
(тэмдэг)	албан тушаал	овог нэр	-ыг төлөөлж гарын усэг

2024 оны ... сарын өдөр

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 7/29 дугаар шалгаралтад
аргаачалын хоёрдугаар хавсралт

Аудитын код _____
..... оны Сарын өдөр

Нам, эвслийн нэр _____
Ажлын баримтын дугаар _____

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь заалттай **НИЙЦЭЖ БУЙ** эсэхийг шалгах хуудас

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тухай хуулийн 37.3-т нийцсэн эсэх (Тийм/Үгүй)			
№	Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ	Уул уурхай, газрын тос, эрдэс баялагийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх	Иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдраптай хүчингүйд тооцох, хөрвүүлэх үзүүлэх
1			
2			
3			
....			



~~Монгол Улсын Ерөнхий аудиторын
дэдүүчийн туслаалгаар батлагдсан
аргачлалын туравдугаар хавсралт~~

Аудитън код

ОНЫ сарын едер

Нам, эвсглийн нэр

Ажлын баримтън дугаар



~~Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны дугаар тушаалдаар батлагдсан
аргачалын дерөвдүүр хавсралт~~

Аудиттын код -

Нам, эвслийн нэр

оны сарын едер

Ажлын баримтын дугаар -

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнг шалгах хуудас

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 9/49 дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын тавдугаар хавсралт (Маягт А)

..... /АЙМАГ, НИЙСЛЭЛ, СҮМ, ДҮҮРЭГ/-ИИН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ НАМ, ЭВСЛИЙН ДАРГА ТАНАА
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлага хангаагүй талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох (нам, эвслийн нэр)-ын /бие даан нэр дэвшигч иргэн (овог, нэр)-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "..... нам" /эвсэл бол эвслийн оноосон нэрийг бичнэ/ /бие даан нэр дэвшигч иргэн (овог, нэр)/-ийн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т аудит хийхэд хуульд нийцээгүй, эдийн засгийн үндэслэл тооцоо судалгаагүй зорилт, арга хэмжээ тусгасан нь хууль тогтоомжийн холбогдох шаардлагад нийцсэн гэх дүгнэлт гаргах боломжгүй байна.

Энэхүү дүгнэлтийн нэгдүгээр хавсралтад дурдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт нийцээгүй, хоёрдугаар хавсралтад дурдсан зорилт, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт нийцээгүй, гуравдугаар хавсралтад дурдсан зорилт, арга хэмжээний эдийн засгийн үндэслэл тооцоо, судалгаа ирүүлээгүй буюу дутуу боловсруулж ирүүлсэн байна.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөрийн холбогдох зорилт, арга хэмжээний зөрчлийг арилгасны үндсэн дээр 2024 оны дугаар сарын-ны өдрийн дотор дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлнэ.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь зөрчлийг арилгасан мөрийн хөтөлбөрөө төрийн аудитын аймаг нийслэл дэх салбар байгууллагат 2024 оны-р сарын өдрийн дугаар албан бичгийн хавсралтын дагуу хөтөлж ирүүлнэ.

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР /гарын үсгийн тайлал/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

АУДИТОР /гарын үсгийн тайлал/

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын тавдугаар хавсралт (Маян Б)

..... аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дугаар сарынний
өдрийн дугаар дүгнэлтийн нэгдүгээр хавсралт

Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т дахь заалттай нийцээгүй зорилт арга хэмжээн

№	Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн 37.3-т дахь заалттай нийцээгүй зорилт арга хэмжээн	Уул уурхай, газрын тос, эрдэс баялагийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх	Зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх	Иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдрагтай хүнээр үйлчилгээ үзүүлэх	Ажлын байранд зуучлах, ажилд оруулах	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон асуудал
1							
2							
3							
...							

Монгол Улсын Ерөнхий аудиторын
аргаачалын тавдугаар хавсралт (Маягт В)
~~2024~~ оны ~~Аж~~ дугаар тушаалаар батлагдсан
аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дугаар сарын ~~2024~~ ...-ний
өдрийн дугаар дунгэлтийн хоёрдугаар хавсралт

..... нам, эвсэл /бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцээгүй зорилт, арга хэмжээ

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын тавдугаар хавсралт (Маят Г)
..... аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын ... дугаар сарын ...-ний
өдрийн дугаар дүгнэлтийн гуравдугаар хавсралт

..... нам, эвсэл /бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-т заасан санхүүгийн эх
үүсвэр, тооцоолол шаардлагатай арга хэмжээ

№	Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Тайлбар
1		
2		
3		

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 3/49 дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын зургаадугаар хавсралт

..... /АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ/-ИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛД

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох (нам, эвслийн нэр)-ын /бие даан нэр дэвшигч иргэн (овог, нэр)/-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн

хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгон авч үзсэн.

Дүгнэлт

.....”нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн овог
нэр -ны /РД:...../”-ийн Аймаг,
нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

.....”нам эвсэл, бие даан нэр дэвшигч”-ийн мөрийн хөтөлбөр
(..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг:”нам эвсэл, бие даан нэр дэвшигч”-д

Хувийг:/тухайн шатны/ Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР /гарын үсгийн
тайлал/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР /гарын үсгийн
тайлал/

АУДИТОР /гарын үсгийн
тайлал/